

|                                                                                   |                                                      |               |
|-----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|---------------|
|  | ДС ББ-ЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН<br>ТЭМДГИЙГ АШИГЛАХ ДҮРЭМ | ДС R-01       |
|                                                                                   | Батлагдсан огноо: 2025-12-25                         | Хувилбар № 01 |

## АГУУЛГА

|      |                                                            |   |
|------|------------------------------------------------------------|---|
| 1.0  | ЗОРИУЛАЛТ .....                                            | 2 |
| 2.0  | ХАМРАХ ХҮРЭЭ .....                                         | 2 |
| 3.0  | НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ .....                                   | 2 |
| 4.0  | НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ .....                             | 2 |
| 5.0  | ҮНДСЭН ХАРИУЦЛАГА .....                                    | 2 |
| 6.0  | ДҮРЭМ .....                                                | 3 |
| 6.1. | Баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээ олгох .....            | 3 |
| 6.2  | Баталгаажуулалтын тэмдэгийг ашиглах ерөнхий шаардлага..... | 3 |
| 6.3  | Баталгаажуулалтын тэмдгийг хэрэглэх .....                  | 3 |
| 7.   | ХАРИУЦЛАГА .....                                           | 4 |

|                                                                                   |                                                      |               |
|-----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|---------------|
|  | ДС ББ-ЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН<br>ТЭМДГИЙГ АШИГЛАХ ДҮРЭМ | ДС R-01       |
|                                                                                   | Батлагдсан огноо: 2025-12-25                         | Хувилбар № 01 |

## 1.0 ЗОРИУЛАЛТ

Энэ баримт бичигт Даян сертификэйшн ББ-ын баталгаажуулсан менежментийн тогтолцооны болон бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний талаар хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, хэрэглэгчдэд баталгаажуулалтын талаар итгэл төрүүлэх, баталгаажуулалт хийлгэсэн байгууллага өөрийн үйл ажиллагааг сурталчилж баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдгийг хэрэглэх аргыг тогтоосон.

## 2.0 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ дүрэм нь баталгаажуулалтын байгууллагаас олгосон баталгаажуулалтын гэрчилгээтэй холбоотой баталгаажуулалтын тэмдгийг ашиглах нөхцөл, шаардлага, хязгаарлалт, хяналт, зөрчил гарсан тохиолдолд авах арга хэмжээг тогтооно.

## 3.0 НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

MNS ISO/IEC 17030: 2004 Тохирлын үнэлгээ - Гуравдагч талын (хөндлөнгийн) тохирлын тэмдэгт тавих ерөнхий шаардлага

MNS ISO/IEC 17021-1:2020 Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага -1-р хэсэг: Шаардлага

## 4.0 НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**4.1 Баталгаажуулсан байгууллага**-ISO стандартын дагуу менежментийн тогтолцоо нь баталгаажсан Даян сертификэйшн ХХК/Баталгаажуулалтын байгууллагын үйлчлүүлэгч байгууллага.

**4.2 Баталгаажуулалтын гэрчилгээ**- Тухайн стандартын дагуу менежментийн тогтолцоо шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.

**4.3 Баталгаажуулалтын бүртгэлийн дугаар**-Даян сертификэйшн ББ-аас баталгаажуулсан байгууллагад олгосон гэрчилгээний бүртгэлийн дугаар.

**4.4 Баталгаажуулалтын хамрах хүрээ**- Баталгаажуулсан менежментийн тогтолцооны хэрэгжилтийн хүрээ, хязгаар.

**4.5 Түдгэлзүүлэлт**-Энэ журам, бодлого, гэрээ болон холбогдох стандартын шаардлагыг ноцтойгоор хангаагүйгээс гэрчилгээний хүчинтэй байдлыг түр зогсоох.

**4.6 Итгэмжлэл**- аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх

## 5.0 ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

**5.1 ДС ББ-ын Гүйцэтгэх захирал** нь гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

|                                                                                   |                                                      |               |
|-----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|---------------|
|  | ДС ББ-ЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН<br>ТЭМДГИЙГ АШИГЛАХ ДҮРЭМ | DC R-01       |
|                                                                                   | Батлагдсан огноо: 2025-12-25                         | Хувилбар № 01 |

**5.2 Баталгаажуулалтын менежер** нь үйлчлүүлэгчид баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээний зөв хэрэглээний талаар зөвлөгөө, тайлбар өгөх, хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна. Баталгаажуулалтын тэмдэг ашиглалттай холбоотой шаардлагын өөрчлөлтийг холбогдох ажилтан болон гэрчилгээ эзэмшигчдэд цаг тухайд нь мэдээлэх, холбогдолтой бүртгэлүүдийг хөтлөх, хадгалах

**5.3 Ахлах аудитор, аудитор** – аудитын үеэр тэмдэг, гэрчилгээний зөв хэрэглээг шалгаж, зөрчил илэрвэл тайланд тусгана.

**5.4 Чанарын менежер** – дүрмийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, үр нөлөөг үнэлнэ.

**5.5 Үйлчлүүлэгч (гэрчилгээ эзэмшигч)** – тэмдэг, гэрчилгээг зөв ашиглах, буруу хэрэглээг нэн даруй зогсоох, түдгэлзүүлсэн эсвэл хүчингүй болсон тохиолдолд бүх хэрэглээг зогсооно.

## 6.0 ДҮРЭМ

### 6.1. Баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээ олгох

6.1.1 ДС ББ нь баталгаажуулалтын хамрах хүрээнд хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд баталгаажуулалтын гэрчилгээг хэвлэж, баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх зааврын хамт өгнө. Түүнчлэн энэ зааврыг вейвсайтаас харах боломжтой.

### 6.2 Баталгаажуулалтын тэмдэгийг ашиглах ерөнхий шаардлага

6.2.1 ДС ББ-ын баталгаажуулалтын тэмдгийг баталгаажуулалт хийлгэсэн байгууллагууд зөвхөн баталгаажуулалтын хамрах хүрээнд, гэрчилгээний хүчинтэй хугацаанд хэрэглэх эрхтэй.

6.2.2 Баталгаажуулалтын тэмдгийг нь баталгаажсан менежментийн тогтолцооны хамрах хүрээнээс гадуур ашигалхыг хориглоно.

6.2.3 Баталгаажуулагдсан байгууллага нь баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээг буруугаар ашигласан тохиолдолд баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах хүртэл арга хэмжээг авна.

6.2.4 Баталгаажуулалтыг түдгэлзүүлсэн, цуцалсан, гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд баталгаажуулалтын тэмдгийг хэрэглэхийг хориглоно.

6.2.5 Баталгаажуулагдсан байгууллага нь баталгаажуулалтын тэмдгийг хэрэглэхдээ “Баталгаажуулалтын тэмдэг ашиглах заавар”-ыг мөрдөнө.

### 6.3 Баталгаажуулалтын тэмдгийг хэрэглэх

6.3.1 ДС ББ-аар баталгаажуулагдсан үйлчлүүлэгч байгууллага нь ДС ББ-ын тэмдгийг интернет, товхимол, танилцуулга, тухайн байгууллагын хэвлэл, сурталчилгааны материал байгууллагын дотор хана, мэдээллийн самбарууд, үзэсгэлэнгийн танилцуулга, вебсайтдаа хэрэглэж болно. Вэбсайт, сурталчилгаа, товхимол, баримт бичигт баталгаажуулалтын талаар дурдахдаа Даян сертификэйшн ББ-аас олгосон гэрчилгээтэй шууд холбогдож, ойлгомжтой байдлаар тусгана.

|                                                                                   |                                                      |               |
|-----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|---------------|
|  | ДС ББ-ЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН<br>ТЭМДГИЙГ АШИГЛАХ ДҮРЭМ | ДС R-01       |
|                                                                                   | Батлагдсан огноо: 2025-12-25                         | Хувилбар № 01 |

6.3.2 Баталгаажуулалтын тэмдэг, логог бүтээгдэхүүн болон бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр бүтээгдэхүүн баталгаажсан мэт ойлголт төрүүлэх байдлаар ашиглахыг хориглоно.

6.3.3 Баталгаажуулалтын тэмдэг, логог сорилтын лабораторийн тайлан, шалгалт тохируулгын гэрчилгээ, хяналт шалгалтын тайлан дээр ашиглахыг хориглоно.

6.3.4 Баталгаажуулалт түдгэлзсэн эсхүл цуцлагдсан тохиолдолд баталгаажуулалттай холбоотой бүх сурталчилгааны материалыг нэн даруй ашиглахаа зогсооно

6.3.5 Баталгаажуулалтын тэмдэг, логог сурталчилгааны материал, бичиг хэрэг, вэбсайт, танилцуулга, компанийн баримт бичиг дээр ашиглаж болно.

6.3.6 Баталгаажуулалтын хамрах хүрээг багасгасан тохиолдолд зөвхөн тухайн баталгаажуулалтанд хамрагдсан байршил болон үйл ажиллагаанд лого тэмдэг тэмдгийг хэрэглэнэ. Баталгаажуулалтын хамрах хүрээ багассан тохиолдолд бүх сурталчилгааны материалыг шинэчилнэ.

6.3.7 Баталгаажуулалтын тэмдгийг зөвхөн ДС ББ-аас баталсан өнгө болон хар-цагаан хувилбараар ашиглана.

6.3.8 Баталгаажуулалтын тэмдэг, логог буруу, төөрөгдүүлсэн байдлаар ашигласан тохиолдолд үл тохирол үүсгэх бөгөөд баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах үндэслэл болно

6.3.9 Дараах үйлдлүүдийг хориглоно. Үүнд:

- Баталгаажуулалтын тэмдгийн аливаа элемент устгах, дараалал өөрчлөх
- Өнгө, фонт, харьцаа өөрчлөх
- Дэвсгэртэй нэгтгэх, гажуудуулах
- Бүтээгдэхүүн баталгаажсан мэт ойлголт өгөх

## 7. ХАРИУЦЛАГА

Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд Даян сертификэйшн ББ нь:

- Үл тохиролд бүртгэх
- Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх
- Баталгаажуулалтыг цуцлах зэрэг арга хэмжээ авах эрхтэй.